



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2020 09 03 № 107 - 2020/06-17-63

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн болон Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Базарын Цээпилдоржийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сэлэнгэ аймгийн болон Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Б.Цээпилдорж нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050” холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020821

## Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Б.Цээпилдоржийн Сэлэнгэ аймгийн болон Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Б.Цээпилдоржийн мөрийн хөтөлбөр /...<sup>5</sup>... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сэлэнгэ аймгийн болон Мандал сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



**СЭЛЭНГЭ АЙМАГ БОЛОН МАНДАЛ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
БАЗАРЫН ЦЭЭПИЛДОРЖИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**




**УРИА: СЭТГЭЛ НИЙЛЖ ЭХ НУТГАА ХӨГЖҮҮЛЬЕ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.**

**ЭРҮҮЛ ЭНХ, ХАЙР ДҮҮРЭН ОРЧИНД ӨСӨЖ ХҮМҮҮЖИХ ХҮҮХДҮҮД**

- 1.1 Эх нялхас, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалж, өсвөр залуу үеийнхэндээ эх орноороо бахархах, Үндэсний хэл соёл, уламжлалаа дээдэлдэг, бүтээлч сэтгэлгээтэй арга ухаанд суралцсан, өрсөлдөх чадвартай, хөдөлмөрч, хүмүүнлэг хүнийг төлөвшүүлэхэд анхаарч, “Ирээдүйн иргэн” хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлэх арга хэмжээ авна.
- 1.2 Багш, сурагчдын хөгжлийг дэмжих сургалтын лаборатори, видео хичээл, цахим сургалтын орчныг бүрдүүлэн, сумын бүх сургуулийн сургалтын орчныг ухаалаг технологид шилжүүлж өндөр хурдны интернэтэд холбох талаар холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулна.
- 1.3 Сургуулиудын номын сангийн фондыг үндэсний болон дэлхийн сонгодог уран зохиолын номуудаар баяжуулах, сургууль бүрийг цахим номын сантай болгох ажлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.
- 1.4 Хүүхдийг ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар бодлого боловсруулан холбогдох байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, Мандал сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдэд зориулсан сэргээн засах, хөгжлийн төвийг байгуулах ажлыг судлан, холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 1.5 Мандал сумын хүүхдийн ордны үйл ажиллагааг дэмжиж, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн аливаа үйл ажиллагааг бүх талаар дэмжин ажиллана.
- 1.6 Сумын болон өрхийн эмнэлгүүдийг нэн хэрэгцээт шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулж, эмч ажиллагсдыг гадаад, дотоодын урт, богино сургалтад хамруулж мэдлэг ур чадварыг нь нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.

- 1.7 Сурагчдад авьяас чадвар, хүсэл сонирхлоо харгалзан мэргэжлээ зөв сонгож, ирээдүйн чиг баримжаа олоход тусалж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.



### **ХОЁРДУГААР БҮЛЭГ.**

#### **ЭРДЭМ МЭДЛЭГТЭЙ, ӨРСӨЛДӨХ ЧАДВАР БҮХИЙ ЗАЛУУ ҮЕ**

- 2.1 Хувийн хөрөнгөөр спортын талбай, цогцолбор барьсан аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжиж, бүх багт спорт талбай, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх санал санаачилга гаргаж, хэрэгжүүлэх бодлого баримтална.
- 2.2 Урлаг соёл, спортын салбарт улсын болон олон улсын түвшинд амжилт гаргасан хүмүүст дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлыг холбогдох байгууллагуудад уламжлан, хамтран хэрэгжүүлнэ.
- 2.3 Зүүнхараа политехникийн коллежийг түшиглэн насанд хүрэгчид, залуучуудад жижиг дунд, ерхийн үйлдвэрлэл эрхлэх чиглэлээр мэргэжил олгон гадаад, дотоодын холбогдох мэргэжлийн байгууллагуудад зуучлан дадлагажуулах боломжийг судалж, мэргэжилтэй ажилтан бэлдэхэд анхаарна.
- 2.4 Зүүнхараа политехникийн коллежийн үйл ажиллагааг өргөтгөж, хүүхэд залуучуудыг түүнд суралцах хүсэл сонирхлыг нь нэмэгдүүлэх зорилгоор дадлагын бааз, тоног төхөөрөмжийг шинэчлэх, сурах орчин нөхцөлийг сайжруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.
- 2.5 Залуучуудын хөгжил, тэдний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн клуб, холбоод, ТББ-ыг дэмжинэ.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ.**

#### **АМЬДРАХ ОРЧИН САЙТАЙ, АЖИЛ ТӨРӨЛТЭЙ**

#### **АШИГ ОРЛОГО НЬ ХҮРЭЛЦЭЭТЭЙ ИДЭР НАСНЫХАН**

- 3.1 Мандал сумын хөгжилд түлхэц болох "Зүүнхараа жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан", "Зүүнхараа ногооны үр шинэчлэх сан", "Зүүнхараа малын үржлийн сан" зэрэг сангуудыг хувийн хэвшил, олон нийтийг түшиглэн байгуулах ажлыг судалж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 3.2 "Хөдөлмөрч Мандалчууд" хөтөлбөр боловсруулж ерхийн үйлдвэрлэл, жижиг, дунд хэмжээний үйлдвэрлэлийг, мал аж ахуй, хүнсний ногоо, газар тариалан, жимс жимсгэнэ, гахай тахианы аж ахуй эрхлэх, мод үржүүлэх, модон бүтээгдэхүүн



- үйлдвэрлэх гэх мэтээр төрөлжүүлэх бодлого боловсруулж холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.
- 3.3 Модны үйлдвэр эрхэлж байгаа байгууллагуудад нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн хийх үйл ажиллагааг дэмжиж, түүхий эд бэлтгэгчид болон үйлдвэрлэл эрхлэгчид хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангана.
- 3.4 Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо байгуулж, экспортын чиг баримжаанд чиглүүлсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.5 Мэргэжлийн холбоодоор дамжуулж чиглэл чиглэлийн ажил мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтуудыг тогтмол явуулах талаар орон нутгийн захиргаатай хамтран ажиллана.

#### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.**

#### **НАСНЫ БУЯНАА ЭДЭЛЖ, НИЙГМИЙН БҮХ ТӨРЛИЙН ХАЛАМЖ ХАМГААЛАЛД ХАМРАГДСАН АХМАД ҮЕИЙНХЭН**

- 4.1 Даатгалаас хөнгөлөлттэй олгодог эмийн нэр төрлийг нэмэгдүүлэх, хүнд сурталгүй түргэн шуурхай түгээх сүлжээг бий болгох талаар холбогдох дээд шатны байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 4.2 Одоо байгаа ахмадын сувиллуудын орчин нөхцөлийг сайжруулж, байнгын тогтвортой үйл ажиллагаатай болгох чиглэлээр ажиллана.

#### **ТАВДУГААР БҮЛЭГ.**

#### **АМЬДРАЛ ТЭМҮҮЛЭЛ, ХӨГЖЛИЙН ЗАГВАР СУМ - МАНДАЛ**


##### **5.1. Аялал жуулчлал тээвэр ложистикийн бүс нутаг Мандал**

- 5.1.1 Иргэд шинэ бизнес эрхлэх, тохилог орчинд ажиллаж амьдрах, үр хүүхдэдээ сайн боловсрол эзэмшүүлэх, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ авах гэх мэт асуудлыг хангасан бүсийн төв болгох /Зүүнхарааг/ асуудлыг судлан, холбогдох байгууллагад уламжилна.
- 5.1.2 Түнхэл тосгоныг сум болгох асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжилна.
- 5.1.3 Зүүнхараа Авто вокзалыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон сумын төсвийн хөрөнгөөр хамтран байгуулах ажлыг санаачлан, зохион байгуулна.
- 5.1.4 Мандал суманд аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн болон гадны иргэдэд сумын хөгжлийн явцад бий болсон шашин соёлын гайхамшигт өв, зан заншил,

өвөрмөц ёс уламжлалыг таниулах “Орон нутгийг судлах музей”-г байгуулах ажлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.

## **5.2. Эрчимжсэн мал аж ахуй газар тариалангийн**

### **шинэ үеийн загвар сум – Мандал**



- 5.2.1 Мандал суманд зөгийн аж ахуй шинээр байгуулж, Мандал сум зөгийн үржлийн инкубатортай болох ажлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.
- 5.2.2 Мандал суманд өдөрт 10 тонн тэжээл боловсруулах чадамж бүхий малын хүчит тэжээлийн үйлдвэр байгуулах хувийн хэвшлийн байгууллагуудын санал, санаачилгыг дэмжинэ.
- 5.2.3 Малын хүчит тэжээлийн үйлдвэрийг түшиглэн Евро стандартын “Сыр буюу бяслаг”-ны үйлдвэр байгуулах хувийн хэвшлийн байгууллагуудын санал, санаачилгыг дэмжиж ажиллана.
- 5.2.4 Малчин өрхийн хоршсон хөдөлмөр, хот айлын сүү цагаан идээгээр хийсэн бүтээгдэхүүнийг сурталчлах, зах зээлд нэвтрүүлэх асуудлыг бүх талаар дэмжинэ.
- 5.2.5 Өрхийн болон жижиг ногооны аж ахуйн талбайг экологийн бордоогоор хангахад чиглэгдсэн чийгийн улаан хорхой үржүүлэх цехийг Мандал сум, Түнхэл тосгонд байгуулах ажлыг санаачилж, холбогдох дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.
- 5.2.6 Мандал суманд хувийн хэвшилтэй хамтран сүүний чиглэлийн үхрийг төрөлжүүлэн цөм сүрэг бий болгох, фермерийн аж ахуйг хөгжүүлэх, малын үүлдэрлэг чанарыг сайжруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 5.2.7 Малын тэжээлийн ургамлыг Мандал суманд тариалж, малын тэжээлийн үйлдвэртэй холбон, худалдан борлуулах ажлыг зохион байгуулна.
- 5.2.8 Жимс жимсгэнэ тариалах, үр суулгацын нөөцийг нэмэгдүүлэх замаар жимсний аж ахуйн салбарыг хөгжүүлэх, тус чиглэлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллана.
- 5.2.9 Элэгдэл эвдрэлд орсон хөрсийг олон наст, буурцагт ургамал тариалах замаар сэргээх, бордоо, ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээг нэвтрүүлж, хөрсний үржил шимийг хамгаалан сайжруулж, таримал ургамлын хэмжээ, чанарыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 5.2.10 Дархан-Уул аймагт байгуулагдах арьс шир боловсруулах үйлдвэрийг түшиглэн Хараа бүс нутгийн малын түүхий эдийг зах зээлийн эргэлтэд



оруулах, экспортлох, үйлдвэр болон малчны уялдаа холбоог бий болгох ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

**5.3 Иргэдийн оролцоотой байгаль орчныг хамгаална.**

- 5.3.1 Ноён уулыг улсын тусгай хамгаалалтад авах ба үүнийг хэрэгжүүлэхдээ тусгай хамгаалалттай газар нутгийн бүсчлэлийг шинэчлэн тогтоолгох асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 5.3.2 Уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагын өндөржүүлж, орон нутаг болон иргэдтэй хамтарч ажиллах эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг холбогдох байгууллагад уламжилна.
- 5.3.3 Уул уурхайн компаниудын тайланг иргэдэд тавиулах ажлыг тогтмолжуулж, нөхөн сэргээлт, хөдөлмөр хамгаалал, нийгмийн хариуцлага, ажлын байрны талаар мэдээлэл өгч үнэлэлт дүгнэлтээ иргэдээс авч байх асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.
- 5.3.4 Бичил уурхай эрхлэгчдийг нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулан, бичил уурхай эрхлэх газрыг хууль ёсны дагуу олгож, тэднийг эрүүл мэндийн үзлэгт болон нийгмийн даатгалд хамруулах зэрэг хууль ёсны эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажиллана.

Мөрийн хөтөлбөр боловсруулсан:



/Б.Цээпилдорж/